



МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ТУШААЛ

Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2022 оны 03 сарын 31-ны
өдөр хүлээн авсан.

2022 оны 03 сарын 17 өдөр

Дугаар А/49

Улаанбаатар хот


Журамд нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 103 дугаар зүйлийн 103.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/192 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Дундаж цалин хөлс тодорхойлох журам"-ын 2.2 дахь хэсгийн "... цалин хөлсөөр тооцно." гэсний дараа "Энэ тохиолдолд дундаж цалин хөлсний бүрэлдэхүүнд нэмэгдэл хөлс болон байнгын бус, нэг удаагийн шинжтэй шагнал урамшууллыг оруулахгүй байж болно. Ажил олгогч, ажилтан харилцан тохиролцсоноор нэмэгдэл хөлсийг тооцох дундаж цалин хөлсний бүрэлдэхүүнд нэмэгдэл хөлс болон байнгын бус, нэг удаагийн шинжтэй шагнал урамшууллыг оруулж болно." гэж нэмсүгэй.

2. Энэхүү тушаалыг 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

САЙД



А.АРИУНЗАЯА



151201427